

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

ОРЧИН ҮЕИЙН ХЯТАД УЛСЫН МОНГОЛ СОНИН СЭТГҮҮЛД ҮНДЭСТНИЙ УХАМСРЫН АСУУДЛЫГ ТУСГАСАН НЬ

Оюун*

*Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Улсыг судлах хүрээлэнгийн профессор

Түлхүүр үг: Хятад улс, монгол сонин сэтгүүл, үндэстний ухамсар, сургаал хүмүүжил, монгол сэхээтнүүд, монгол сурагчийн хурал.

ХIII зуунд алдар нэрээ дэлхий дахинд мандуулж, нэг үе сүр хүчээ бадраан дэлгэрсэн монгол угсаатан Чин улсын хэсэглэн тараах, ᠑ гүнгийн өргөмжлэл хүртээж өөртөө татах, шашин дэлгэрүүлж мунхруулан номхотгох бодлогын 200 гаруй жилийн ноёрхлыг өнгөрөөгөөд ХХ зуун болж ирэхэд нэгэнт ядуу хоцронгуйллын туйлд хүрч, "үхээнц буурай ард угсаатны дотор багтсан"¹ байна. Нэн ялангуяа Чин улсын сүүлч үеээс эхэлсэн "иргэдийг нүүлгэн хилийг бататгах" бодлого ба Бээжингийн засгийн газар болон Нанжингийн засгийн газрын хэрэгжүүлсэн онцгой орон гаргах буюу муж байгуулахаар дамжиж "иргэдийг нүүлгэж, газар тавин атар хагалах, Монгол орны улс төрийн байгууллыг нэгмөсөн муж сианы байгууллаар орлуулж, монголчуудыг улс төрийн талаар, газар орны талаар хэсэглэн салгаж үндэстнийг устгах"² бодлогын үр дүнд "дотоод Монголын засаг төр нь харанхуй, эд ашиг ань эвдэрхий, утга соёл нь хоцронгуй, ард олны амьдра-

лыг хамгаалахуйяа бэрх, сургаал хүмүүжил нь хэлэлцэх газаргүй, зан ааль нь утга гэгээн бус"³ болжээ. Иймийн учир "тамын дор, нимгэн мөсний дээр амьдарч бүй гаслантай, түгшүүртэй"⁴ монгол тоонтоо дуудан сэргээж, "хэдэн зуун түмэн ард олноо, эрх тэгшийн оронд хүргүүлж, бүрэн ардын засаг засралыг олуулах"-ын⁵ төлөө Монголын сэхээрсэн залуучууд ба дээд давхаргын хүмүүс тохиол бүхнийг ашиглан сонин сэтгүүл эрхэлж, үндэстнээ хүчирхэгжүүлэх арга замыг эрэлхийлж, ард угсаагаа мандуулах тухай сурталчлан ухуулсан байна.

Доройтон буураад мөхөхөөр болсон үндэстнээ мандуулан хөгжүүлэхэд юуны өмнө сайн арга замыг эрж гаргах хэрэгтэй. Монголоо мандуулах сайн арга замыг олоход доройтсон шалтгааныг задлан шинжилж, "өвчинд тааруулах эм олбол сая үндэстнээ тэнхрүүлж чадна" гэдгийг тухайн үеийн сэхээрэгсэд гүйцэд таньж байсан юм. Иймээс монгол сурагчид буюу монгол сэхээтнүүдийн эрхэлсэн сонин сэтгүүлийг найруулах эрх нь Монголын дэвшсэн хүмүүсийн гарт байсан сонин сэтгүүлүүд, тухайлбал, "Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал", "Ирээдүйн монгол", "Шинэ

монгол", "Манхын хонх", "Дахин мандсан монголын чимээ", "Хөх туг" зэрэг сонин сэтгүүлүүд цөм үндэстний доройтсон шалтгааныг задлан шинжлэхээс гардан авран мандуулах арга замыг сүвэгчилж, энэ бүхнээ маш яаралтайгаар монголчуудаа уламжлан ухуулж байсан юм.

Нэг. Монголын доройтсон шалтгааныг эрэлхийлсэн нь

Сэхээрсэн монголчууд үндэстний ихээхэн доройтсныг Чин улсын Монголд явуулж байсан бодлогоос шалтгаан эрсэн мөртлөө бас Иргэн улсын хоёр үеийн засгийн газрын Монголд авч байсан бодлогоос ч учир шалтгааныг эрж, Чин улсын засгийн газрын хүчирхэг Монголыг доройтуулан юм бол, Иргэн улсын Засгийн газар монголчуудыг нэгмөсөн мөхөөх замд оруулсан юм гэж үзсэн байна.

1. Чин улсын Монголыг доройтуулсан бодлогыг илчилсэн нь.

"Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эрхлэн үүсгэсэн дарамлал"-ын "Монголдоо сануулах үг"-д: "Манай Монголын буурай болсон учир нь хэдэн зүйлтэй холбоотой. Ард олон бүгдээрээ эв найрамдалгүй нь нэгд, соёл боловсрол нь хүнээс хожигдсон, хоёрт, сүсэг бишрэл нь төөрөгдсөн, гуравт... урьд Манжийн төрийн үед анги бүлэг хуйвалдан аймаг угсааны санал бодол өдөөн болоод, өөр хошууны хүнийг цагаачин хэмээн нэрлэн хар Хятадыг хүндэтгэн үзэх, нэгэн хошуунд гачигдал тохиолдвоос өөр олон хошуу өчүүхэн ч тусалгүй бөгөөд заримд нь хажуунаас ханал болон сууж, эс бөгөөс гал дээр тос дусааж хэргийг ихэсгэх нь даруй монгол хүний найрамдалгүйн үлгэр болой. Соёл боловсрол хэмээгч ухаан оюуны уг үндэс тул боловсролгүй бөгөөс утга оюун нээгдэхгүй, утга оюун

нээгдэхгүй бөгөөс ой билэг мунхран баларч, ажил мэдэл бүтэхгүй болон улс гэрийн тогтнох сөнөх, аймаг угсааны мандан буурах, ард олны амар зүдүүр, орон нутгийн төвшин төлвийг огт анхаарахгүй өөр аймгийн хорлох, эзэрхэг улсын дарлах, уул голын өнгө харих, эрх ашгийн хасагдахыг огт мэдэхгүй, өдөр бүр амгалан жаргаланг эрж цэнгэлдэхийг эрхэм болгомой... Манай монгол хүний сүсэглэн бишрэх нь бурхан шашин, гэвч бурханы гол зорилт нь эвлэрэн энэрэнгүйгээр үл алахыг эрхэмлэснээс элдэв зүйлийн хэргийг цөм бурхнаа даатгаваас даруй сэтгэлчлэн бүтээж өгмүй хэмээн соёрхсонгүй болой. Харин манай монгол хүн буруу сүсэглэж элдэв зүйлийн хэргийг бурхнаа даатган залбирч өөрөө чармайхгүй. Ганц амаа ангайн тэнгэрийг харж нэг үмх будаа өгмөй хэмээн санаад тариалан төмсийг тарихгүй, тарьснаа таягдан хаяад хамаарахгүй, адуу малаа эзгүй тавин ажил амьдралаа анхаарахгүй ганц хувь заяаны сайн мууг хэлэлцмөй"⁶ гэж Монголын доройтсон шалтгааныг нягтралгүй, утга соёл хоцронгүй, шашин суртахуунд дарлагдсан хэмээн үзжээ.

"Ирээдүйн монгол"-ын "Монгол угсаатны доройтон муудсан үнэн учир"-т: "Бурхан шашин хэмээгч монгол угсаатны дэгжин сайжрах зам дээрх хамаг их харшил болой... Энэхүү үнэн учрыг хянавч хамаг их нэр алдаршсан эрхэм монгол угсаатан нь үнэхээр балай суртахууны хорыг амссан харгайгаар өдөр ирэх тутам доройтон муудах зүг явж байна... Эдүгээ монгол хүний санаа сэтгэлийн дотор агуулагдан байх нь мөн хойд төрлийн заяа буянаа хүлээх санаа болой... Ийнхүү нэгэнт Чингис хааны үеийн хариуцах эсэргүүцэх цог жавхлантай өчүүхэн төдий ч үгүй болоод мөн бус угсаатны

эрх хүчинд захирагдах боол шивэгчин болсон болой, бас хүнийг үхүүлэх төрүүлэх эрхийг цөм бурхны гарт атгуулж хүн ардын эрхээр болгож үл чадмой хэмээн санамой. Иймийн тул хатуу зориг амьдрах хүчин, өөрийн бишрэл, хожимын хүсэл эрсийн эрдэмт сахил хүртэл бүрнээр гээгдэж, ганц байх нь доройтон муудсан чадал тэнхээгүй амар жаргах залхуу угсаатан болохуйд хүрсэн болой"⁷ гэж Монголын доройтсон шалтгааныг шашинд мунхарсанаас болжээ гэж үзжээ.

"Дахин мандсан Монголын чимээ"-ний "Дурдан санах хэдэн үгс"-т: "Манай монгол эв найрамдлаа алдаж элэг сэлэг явсаар, эдүгээ эл улсаас буурай дорой болсныг хянаваас, манай монгол аймагтнууд нэн найрамдваас зохимой, үүнд эс найрамдваас гангийн ёроор ийн жагссан мэт, сааргүй зовнил нь нүдний өмнө болохуй... амар төвшин умдаж бурхан чөтгөр сахиулсны зэргийг юүдэлж байх харанхуй бүдүүлэг монгол ардыг нийтээр хашгиран сэргээж жолоодож удирдан, буурай туйлдсан угсаагаа гэгээхэн дөт замаар дагуулан оруулах нь монгол угсааны мөхөшгүй завшаан тул, хөхүүлэн сэнхрүүлж хүмүүжүүлвээс нэгэн их чухал үүрэг мөн... Эртнээс өдий хүртэл ирсэн учир шалтгаан нь манай Монголын Лигдэн хааны үеэс салалцан бутарч ирснээс улам улмаар утга соёл ухран яазгуур хотол буурсаар Дунд улсад мөргөгдөж хувь хувьдаа зэрэг хэргэмийг өргөмжлөн хошуу чуулган хэмээн хуваан өмчилж, хоорондоо хоёр улс мэт, хоёр хошууны ард өшөөтөн адил нэг нэгээ чигчэн гаданчин зэргээр хэлэх... Хэдийгээр монгол угсаа нэгэн хэмээн хэлэвч нийгэм найрамдлаа алдаад нэгэн угсаа болж чадахгүйгээр салхинд цацагдсан шар бурцаг мэт сарнисан бутарсан

угсаа болсон"⁸ гэж хамтран тэмцэл, шашин суртахуун, утга соёлын талаас доройтсон шалтгаанаа эржээ.

Мөн энэ сэтгүүлийн "Манай залуучуудын тушаал үүрэг"-т: "Манай монгол угаас амар жаргалд ташаарсан ба урагшлан сайжрах явдалд хожимдсон хэдэн зүйлийн сэдвийг ялгаварлан гаргаж илэрхийлмой. 1. Юань улс доройтсоноос хойш Чин улсын үед манай ард иргэдийг хувааж олон газарт суулган улсын гол хүчнийг алдуулсан учир. 2. Манай залуусыг сургаал сурталд явуулахгүй бөгөөд нэн ялангуяа лам хүнийг үлэмж тавьж, нэг үе охид үр ач наргүй болгон хүн амыг цөөрүүлж угсаа аймгийг зөөлөн буурай болгохуйн уг үндсэн болжээ. 3. Манай монголчууд нь мэдлэгийг нэмэгдүүлэн ухаанаа нэмэгдүүлэх зүйлийг огт нарийвчлан санахгүйгээр татсан суртал болгож, тус бүрийн нэгэн үеийн амар жаргалыг бодсоор зүтгэн чармайх зориг нь үгүй болоод залхуурах зан нь дадал болой. 4. Утга соёл юугаа мандуулах онцгой тустай сайн үйлсийг үйлдэхүй, ноёд нь ямагт өөрийн зэрэг тушаалаа хамгаалан идэх амаа бэлдэхийг санасаар хараат угсаа олноо доройтоход хүргэжээ. 5. Сүм хийдэд суугч их бага лам нар нь, тархи дотроо бурхан шашны нэрийг барин, бусад олны эд хөрөнгийг төлөөсгүйгээр алдуулан авах ба... бас тив ертөнцийг хоосон хэмээх хөндий хоосон үгсийг алдаршуулан нийгмийн урагшлах чармайллын урам зоригийг мунхруулахаар зохиогоод... 6. Манай монголчууд болгоомжгүйгээр шарын шашны гүн нарийнийг үл ялган нэгэн үзүүрт тэнэг сүсэгт итгэж тэдүйгээр тэр шашны нэрийг худалдан хуурмагаар мунхруулагчдын үгэнд нэрвэгдээд хожмын сүнс ба хойд төрөлдөө сайн хутга олсугай хэмээн

санж, эдүгээ ертөнцийн аж амьдрахаа хүндэтгэн, эд хөрөнгөө мэхлэгдсээр, одоо үгээгүй ядуугийн түйлд хүрсэн шалтгаан болжээ"⁹ гэж доройтсон шалтгаанаа 6 зүйлээс эржээ.

“**Х**өх туг” сонины "Монгол амьдралыг хөгжүүлж алхам дэвшиж байх нь"-д: "Монгол хэмээгч 700 оны урьд баруун хоёр тивийг цэргийн баатраар эзэлж ертөнцөд ганцаар байгуулсан их улс болж мандахуй, ганц монгол угсаатан нь цэргийг хүндэтгэн бичгийг хөнгөлж, тариачин, урчууд, худалдаачин зэргийн эрдмийг эрхэм-лэн шүүмжилсэнгүй бөгөөд жаргаж амарсаар залхуу дадлыг олсон дээр өнгөрсөн улс монголд мунхруулах засгийг хэрэглэн явуулж, Монголыг утга соёлоос гээгдүүлж, иргэн улсын догшин засгийн үед Монголын амьдралын газар шороог өдрөөс булаан залгиж, эрх сүр нь улмаар буурч нэгэнт үхмээр газарт иртэл"¹⁰ гэж монгол аймгийн доройтсоны Чин улсын мунхруулах бодлого ба Иргэн улсын догшин засгаас болсныг таньж байсан юм.

Мөн тус сонины "Монгол аймагтан бид нар"-т: "Манай монгол аймаг уг нь ариун цагаан тархитан, үнэнхүү шударга журамтан нэгэн явдалд итгэвээс үхэн үхтэл үнэнч буй хэмээн итгэх тул, харгис муу хуурмаг залхай Хятадын арга ухаанд мэхлэгдэн харанхуй мананд төөрөөд буруу замд орсноос хойш хэдэн зуун жилийг өнгөрүүлэн хувь заяагаа сахиж, бурхан тэнгэрийн авралыг хүлээсээр энд хүрч ирээд"¹¹ гэж буурай дорой болсон шалтгаанаа эржээ. Энд Чин улсыг "өнгөрсөн улс" гэж бөөрөнхийлэн авсан буюу Манж чингийн засгийн газар ба Иргэн улсын засгийн газрыг нийлүүлээд "харгис муу хуурмаг залхай Хятад" гэж нэрлэснийг "Хөх туг" сонин

Японы эзэмшил дэх "Манж улс"-ын хараанд байснаас болсон юм гэж ойлгох ёстой.

Эл сонины "Монгол угсаатны өнгөрснийг нэхэн бодож монгол залуус бид бүгдээрээ чармайцаая хэмээх бодлоо илтгэсэн нь"-д: "Урьд Чингийн үед хүрч ирээд Монголын ноён гүн нарт... хий хоосон зэрэг өгч тус тусын нутаг хошуунаа суулгаж, газар орныг сахиулснаас бус, манай Монголын утга уянгыг мандуулж, улс төрт хүндэтгэн хэрэглэсэн учир огт үгүйгээр үл барам, харин аль нэгэн сэцэн сэргэлэн баг хүүхдийг нь үлдээж бусдыг нь үсийг тайрч улаан шар дээл өмсгөж, төвд номыг уншуулж, буяны зүг сайн зам бурхан болохын мөрт орвой хэмээн хөхүүлэн лам хүнийг онцгой их хүнд үзэж, хишиг шан ч их бөгөөд, хүч тамирыг нь үл дуусгах хүнд их ажлыг үйлдэхүйд хүн бүр бахархаж, хөвгүүнээ лам болгохыг мэдсэнээс бус хорт санааг нь ухсангүй болой"¹² гэж Чин улсын Монголд явуулсан өргөмжлөлийн дүрэм ба шарын шашнаар монголыг мунхруулж, үндэс угсааг харлуулах ойртсон "хорт санаа"-г илчлэн ухуулжээ.

2. Иргэн улсын Монгол оронд атар газар эзэмших муж байгуулж, "засаг засрал"-ын эрхийг булаасныг шүүмжилсэн нь

"Бэйпинд байх монгол сурагчийн хурлын эхлэн үүсгэсэн дарамлал"-ын "Нэгэн ардын угсаатны мөхөж устахын учир"-т: "Түүний "ардын угсаатан" устаж сөнөхийн учир нь гурван зүйлийн хөнөөлөөс гарахгүй... даруй аяандаа улрахын хүчин, засаг засралын хүчин, эд ашгийн хүчин мөн.... Манай монгол угсаатан бол энэ гурван зүйлийн хөнөөлийг давхарлан амсаж буй.... Даруй Хятад угсаатны энэ гурван зүйлээр манай Монголыг хядан мөлжиж

ахуй нь чухам хүнд нь болой... Дотоодын үхээнц буурай угсаатныг мөн энэ гурван зүйлээр хөнөөн дарлаж, элдвийн уран үгээр олон Монголыг мэхлэн, өөр угсаатныг цөм өөрийн угсаадаа хувилган дагуулж авсугай гэж буй... Энэ нь манай Монголын дотоодоос үүсгэсэн аяндаа улрахын хүчнийг шууд амсах хөнөөл болой... Дотоод Монголын эл хошуунаа цөм шиан байгуулж, монгол хүний засаг засралын эрхийг цөм булаан авч, огт хэрэггүй ноён гүнгийн цолыг өгч, чухам мэдэл эрхийг цөм шианы гарт оруулж, Хятадаа хамгаалан Монголыг дарлаж байхын учир... Энэ нь олон Монголын бүгдийг нүдээр үзэж, биеэр амсаж байх засаг засралын хүчнээр дарлах хөнөөлтэй... Манай монгол угаас үйлдвэрийн хөрөнгө, арилжааны хөрөнгөгүй тул алба хэрэгслийн зүйлийг цөм хүнээс эрмэлзэх бөгөөд залжин худалдаачны уран аргад оногдож, ашиг зоосоо учиргүйгээр хожигдох олон бий, монгол газрын эл зүйлийн гаралт нь элбэг, гэвч олонхын эрх хүний гарт орж, өөрийн эзэн болж чадахгүй.... Энэ нь эд ашгийн хүчнээр биднийг хөнөөхийн их төлөв болой"¹³ гэж нэг үндэсний устаж мөхөхийн гурван шалтгаан - хувьслын хүчин (шилдэг нь үлдэж шаар нь орхигдох), улс төрийн хүчин ба аж ахуйн хүчийг заан гаргаж, энэ гурван талаар цөм хөнөөл амссан монгол үндэстэний элэг эмтрэм хувь заяаг тооцжээ.

Тус сэтгүүлийн "Монголыг зохистой мандуулах явдал хөрөнгө"-д: "Манай монгол угсаатан энэ өдөр болоод нэгэнт бүдрээд дахин босхоход бэрх болжээ, эдүгээ боомтын гадна ундрэн суугаад, утга соёл нь мөчид болж, ухаантай эрдэмтэн ховор болж, эл явдал цөм дэггүй болсон бөгөөд, орон газар нь агуу өргөн дээр аман тоо

нь өчүүхэн цөөн болсноор, өөр өөр угсаатны халдан дурлах сэтгэлийг өдөөн босгож, эл эзэрхэгтэн нарийн дарлан мөлжихийн зовлонг амсаж амой, энэ учрыг хэдэн зоривоос татлан гаргаж, олноо өргөн сонсоосой"¹⁴ гэж Иргэний засгийн газраас Монгол оронд элдвийн аргаар малын бэлчээрийг хагалж газар нутгийн булааснаас монгол хүний амьдрал өдөр ирэх тутам хүчир бэрх болсон, цааз хууль тэгшгүй болж, Хятад Монголын хэрэн заргад монгол хүн ёс байгаад ёсоо олохгүй, нутаг усаа хүчээр булаалгаж, гэр хөрөнгөө алдаж элгэн садан хагацсан байдал, арилжаа худалдааны дунд Хятадын зүсэр худалдаачинд мэхлэгдэж байх зэргийг дурдаад "одоо удалгүй монгол угсаатан ертөнцөд үгүй болох магад" гэж эмгэнэжээ.

Мөн тус сэтгүүлд нийтэлсэн "Монгол угсаагаа бататгамай" гэдэгт: "Эдүгээ ийм зөөлөн буурай угсаатан болж бусдад дарлагдан байх аж, үүнийг эргэцүүлэн бодвоос, нэгд, эрдэм соёл баларч, уг үндэсний үсэг хэлээ умартсан нь олон нь болжээ, хоёрт, эрх хүчээ алдаж олон ардын санал зориг нь эс нийлж, гуравт, орон нутгаа алдаж аж төрөн амьдрах газаргүй болсноос ийм болжээ. Тиймийн тул эдүгээ цагийн хувьсгалд эртээнээс урагш дэвшин монгол угсаагаа мандуулахад бараг амжихгүйд хүрэхүй"¹⁵ гэж үндэстний доройтсон шалтгааны утга соёл ба газар нутгаа алдсанаас болсон хэмээн үзэж, хувьсгалын аргаар Монголоо мандуулахыг дурджээ.

"Монгол"-ын "Одоо манай угсааны мөхөхийг шүүмжлэх нь"-д: "Аяа, манай Монголын өнөөх байдал өдөр байсаар улам түгшүүртэй болжээ. Хэцүү дайснууд хэдэн зүгээс шахамдуулан, өлсгөлөн чоно адилаар өөрийн

болгон үзэж урж булаалдан идсүгэй хэмээх нь, лав манай хүн ардын тэнэг мунхаг, эрдэм чадлын мөхөс ба эд юм байгаад оюун сууж оролдохгүйн улмаас тийм зэрлэг сэтгэлийг үүсгэснээ, үнэхээр аюул буюу... Монгол нэгэнт өглөөний сүүдэр мэт түшүүртэй болов. Одоо хэрвээ доорх хэдэн ангийг нийлүүлэн хэлвээс мөхөх нь зогсоогоор хүлээвээс болой. 1. Өөр зуураа эвдрэлцэн нэгдэх нь. Манай аймгийн нэгэнт муу юмыг далдлан хэлэх ч хэрэггүй... 2. Гадар зовлон улам хэгжүүн болсон нь... Өөр монголыг муж болгон хувиргаснаа... Эдгээр газрын хүн ард эдүгээ олонх нь хайлан шингдээд газар шорооны эрхийг нэгэнт аван бэлчээрлэх амьдраг, бас булаагдахуйд хүрчээ... 3. Хуучин дүрмийг сахисан нь... Манай Монголын цөөн тооны ван гүн эрхтэн нар... Хувьсгал хэмээхийг сонсмогц зориг зүс хэмхрэн залуус хэмээгчийг үзвээс догшин гөрөөс адил, өөрийн тэр хэргэм зэргээ хайрлан хамгаалахын тул өөр хүний бошгыг халахаас айн эл шинэ үйлдэх хэрэг бүхнийг аргалан эвдэлмэй, сургуулиудыг эс үүсгэх ба засаг засалтыг эс шинэтгэх, цэргийн үйлийг эс оролдох зэргээр үүнийг гэрчилж болном"¹⁶ гэж Монголын доройтсон шалтгаан ба түгшүүрт байдлыг өөр зуураа бөөрөнхийлөхгүй, газар усны булаагдсан, хуучныг баримталж шинэчлэхийг хүсэхгүй гэх мэтийн гурван талаар дүгнэжээ.

“**М**онголын чимээ”-ний “Монгол засгийн өнгөрсөн хийгээд эдүгээ ба ирээдүй байдлын өгүүлэл”-д “Дундад улсыг байгуулж таван угсаа хамтаар найралдах учир, төрөлхөөс чигч шударга монгол хүн нь түүнээ харгалзан үзэхүй нь тэгш адил байхаар санаж, чуха хүү халуун үнэнчээр

доошоо хандаж эдүгээ хүрсэн болвоч хэрхэн харин амандаа таван угсаа хамт найралдах улс болсон хэмээгдээд тусыг өчүүхэн төдий олж завшсан зүйл огт үгүйгээр үл барам харин Монголын нэгэн угсаатныг гадаад аймаг лугаа адил үзэж газар шороо хийгээд гаралт хөрөнгийг нь түрэмгийлэн эзэрхэж аливаа эрх хэмжээг нь муж шианд багтаан оруулж монгол хүний амьдрах замыг таслахад хүргэжээ”¹⁷ гэж илчлэн Дундад иргэн улсын үе дэх монголчуудын гашуун зовлонт хувь заяаг үнэн зөвөөр олон түмэнд таниулахаар чармайж байжээ.

Хоёр. Монголоо мандуулах арга замыг ухуулсан нь

XX зууны 20-40-өөд оны хооронд монгол хүмүүсийн эрхэлж байсан сонин сэтгүүлийг шүүж үзвэл, бүлэглэн нягтарч бүлэг болон бүрэлдэх, утга соёлоо дээшлүүлэн ардын мэдлийг нээх, сурган хүмүүжлийг тогтмолжуулан үндэстнээ мандуулах, мунхаг бишрэлийг арилган лам хуврагыг хязгаарлах, үнэн үйлсийг эрхэмлэж аж ахуйгаа хөгжүүлэх, ард олон нягтран “өөрөө чармайн байгуулах” зэрэг арга замыг дурдан ухуулж, монгол ард олныг үндэстнээ мандуулахыг өөрийн үүрэг болгон урагш чармайн тэмцэхийг уриалсан байна. Энэ тухай төлөөлөх чанартайгаас хэдийг дурдвал:

1. “Бэйпинд байх монгол сурагчийн хурлыг эхлэн үүсгэсэн дарамлал”-ын ухуулга. “Монголдоо сануулах үг”-д: “Энэ өдөр монгол угсаагаа дэгжүүл-сүгэй хэмээх эрхгүй монгол ард бүгдээр хэн алины хязгаар ялгаврыг хаяж, энэ тэр хэмээн хуваахгүй, санаагаа нягтлан хүчнээ нийлүүлэн зовлон зүдрэлийг хамтатган, үхэх төрхийг цугаар болоод олон сургууль байгуулан олон улсын шинэ мэдлэгийг авчирч монгол бичгээр

орчуулан, олон ардыг цөм монгол бичиг боловсруулан аймаг угсааны бодлыг дэгжүүлэн газар орны засаг захиргааг шинэтгэн сайжруулж, үйл заяа хэмээхийг халж ямар явдлыг ч цөм хүний хүчнээр бүтээж болмой хэмээн бодож урагш хүчлэн чармайваас аймаг угсаа хэрхэн үл мандах ажээ"¹⁸ гэж Монголоо мандуулахад хамтран тэмцэх, сурган хүмүүжлийг эрхэмлэх, засаг захиргааг шинэчлэх хэрэгтэй гэж үзжээ.

"Монголыг зохистой мандуулах явдал хөрөнгө"-д: "Энэ өдрийн арга нь, хатуу зоригоор халан шийтгэж, хүчин чинээгээр хэвлэн засваас зохимой, боловсрол хүмүүжил хэмээх, цэргийн үйл хэмээх, засаг захиргаа хэмээх, сүрэг бэлчээр хэмээх, ажил хөрөнгө хэмээх, ажил амьдрал хэмээх, ардын хамгаалал хэмээх, хийгээд зан ааль хэмээх зэргийн үйлсийг дэс дараалан үүсгэж, үнэмшлэн үйлдвээс... Манай Монголын угсаатны хожмын буян болж болмой... Сургаал хүмүүжил хэмээгч зуун зүйлийн үндэс болох бөгөөд суртал шийдвэр хэмээгч улсыг хүчирхэг болгохын уг болой... Иймийн тул хурдхан элбэг арвин сургууль байгуулж, эрдэмтэн оюутныг олонд хүмүүжүүлэн гаргаваас зохимой"¹⁹ гэж дурдаад нийтийн сургаал хүмүүжил, ажил хөрөнгийн сургаал хүмүүжил, багшийн дүрэмт сургаал хүмүүжил, тусгай ангийн сургаал хүмүүжлийг хөгжүүлэх арга замыг дурдсан байна.

Одоо манай угсааны мөхөхийг шүүмжлэх нь"-д: "Аяа! Хүнийг түшин амьдрах нь, эцэст үл болмой, өөрөө чармайн байгуулбаас, эцэг тэнгэр сая ивээн тэтгэмой, угсаа аймаг аймшигтай болов, ард олон боогдолтой болов, энэ үлдэн сөнөх орхицны хооронд үс хавчуулж үл болмой, олны сэтгэл хот бүтэн, уулан

хэдыг нүүлгэж болно, шив сөхлөө, бүх манай аймаганд хүнд гүнээ эрмэлзэх нь, нэгэн сэтгэл эрдмээр харилцан тусалж угсааг хамгаалах, удмыг бататгахаар өөрийн үүрэг болгон урагш ширүүн тэмцэлдэн, амь тавьсан Монголын сүнсийг эрлэгийн үүднээс эхлэн авчрах ажаамуу, хэдэн зуун түмэн монгол тоонотууд бүгдээр чармайцгаая"²⁰ гэж өөртөө бие даасан улс төрийг байгуулахыг уриалжээ.

2. "Ирээдүйн монгол"-ын ухуулга. "Монгол угсаатныг дахин мандуулах үгс"-т: "Эдүгээ монгол угсаатныг дахин мандуулах үгсийг доор бичье. 1. Угсаатны ур чадлыг мандуулах учир, гадаадаас ирсэн гашуун зовлонг арилгах арга нь, мөн монгол угсаатан өөрсдөө хамтран нийлж, гадар дотрыг хамагаалваас сая чин хүчтнийг дийлж чадмай... Үүнээс гадна монгол угсаатны хуучин байсан сайн сайхан ёс эрдмийг бадруулах бөгөөд өөрийн хүчнийг бас батлан дэлгэрүүлмой. Ийм болбоос монгол угсаатан даруй нэгэн бүрэн бүтэн чадалтай их угсаатан болж гадаад хүчтэй улс болно. 2. Монгол хүний үзэл мэдлийг бадруулахын учир, утга соёл нь нэгэн угсаатны дахин мандахын гол ёс бой... Эдүгээ манай монгол хүн бүрийг үсэг таньж, эдүгээгийн шинэ цагийн мэдэл чадварыг дэлхий дахинд байх эд таваарыг цөмөөр үйлдүүлж чадваас зохимой, үүнд бас цэргийн хэрэг явдлыг сургаж хүн ардыг хамтын замд явуулбаас манай монгол хүний үзэл мэдэл даруй бадрахын зүгт зүгэлмой. 3. Орчлонгийн үйлдвэрийг дэлгэрүүлэхийн учир, манай Монголын орчлонгийн үйлдвэр нь... бэлчээрлэх бөгөөд гөрөөчний явдлыг үйлдмой, иймийн тул эдүгээ бэлчээрлэх ба гөрөөлөх аргыг сайжруулах явуулбаас... Монгол угсаатан үүнээс хойш дахин мандахын замд

орох болой. 4. Бичиг унших бөгөөд хувьсгалын хэргийг үйлдэх учир... Сэтгэлд хувьсгалын явдлыг бодож Монголыг дахин мандуулах санал байвч ийм цагт эрдмийг сайн уншиж ухаан санаагаа сайжруулан хүчин тэнхээг тэжээн гүйцэтгэж чадваас, үүний Монголын эрдэмтэн хэмээн нэрлэж монгол аймгийн нэгэн хувьтны ач тусыг гүйцэтгэн чадмой.

Гурав. Угсаатны тэргүүлэгчийг таниваас зохих учир

Бидний монгол угсаатан.... Угсаатны тэргүүлэгч Дэмчигдонровыг таниваас зохимой. Бид бүгдээр цөм түүний захиаг дагаж өөр өөрийн хүчин чадлаа гүйцэтгэн хэрэг явдлын үйлдвэрийг сайн үйлдвээс монгол угсаатан сая дахин мандахын нэгэн өдөр баймой" гэж Монголоо мандуулах 5 аргыг дурджээ.

"Манай монгол угсаатан өөртөө сэхэн босч ард угсаатнаа мандуулах чармайваас зохих учир"-т: "Эдүгээ манай Монголын амин судас нь монгол угсаатны төлөө зүтгэгч байх олон эрдэмтэн багш нар өчүүхэн төдий сэтгэл болгон санамой. 1. Засаг засалтыг чанд засан залруулж явуулмой... 2. Хошуу бүрийн нэгэн жилийн доторх эд мөнгөний хэрэгслийг нэгтгэн бодож тогтоомой.... 3. Эл хошуудын сүм хийд газарт сургууль хөгжөөн байгуулмой... 4. Үнэн хөрөнгийг хөгжөөн мандуулмой" гэж Монголоо мандуулах 4 зүйлийн бодитой аргыг дурдаж, эдгээр 4 талын ажлыг биелүүлэхэд монголчууд нэгдэн нийлж, нэгэн хүчин нэгэн зоригоор чармайх бөгөөд гадаадын дэвшсэн соёлыг хүлээн авч, өөрийн үндэстнийхээ хоцронгуй муу зан суртлыг бүрмөсөн устгаад шинэ амьдрал үзэл, шинэ ёс дүрэм, шинэ утга соёлыг байгуулан хөгжүүлбэл монгол угсаат-

наа дахин мандуулж чадан гэж ухуулсан байна.

Үүнээс гадна, "Ирээдүйн монгол"-ын "Монгол хүнийг алба зүйлийн үйлс хийж сургах", "Монгол залуус нэн даруй ард угсааны үйлдвэрийг хүчлэн үйлдвээс зохих учир", "Бид бүгдээр зүтгэж монгол тоотыг мандуулах санаа", "Сэтгэл санаа болон засаг захиргааг нэгтгэх учир", "Аюумшиг ихдсэн Монгол"-д монгол угсаатан нэгдэн нягтрах, чармайн зүтгэх, ажил үйлсээ хөгжүүлэх, утга соёлоо бадруулах, сурган хүмүүжлийг хөгжүүлэх, өөрийгөө засах эрх тэгш болох зэрэг үзэл зорилтоо илтгэн ухуулсан байдаг.

“**Х**өх туг” сонины ухуулга. "Сургаал хүмүүжүүлэл хийгээд монгол ард угсаа"-д "Манай Монголын охь манлай тийм их улсыг байгуулаад энэ өдөр яаж ийм буурай болсон байна хэмээвээс, учир олон боловч онцгой нь сургаал хүмүүжлийг эс хайхарсан нь бий, эдүгээ бид үүнийг мэдэж... Манай сургаал хүмүүжлийг сайжруулан бадруулсугай хэмээвээс түүний уг суурийг хадаад үүний маш харшил болж, лам нарыг зохистойгоор зохисыг үзэн арилгаж, сургаал хүмүүжлийн уг үндэс болох охидын сургаал хүмүүжлийг хөхүүлэн явуулж, дараагаар лам болохыг цаазлан зогсоон газар бүр сургуулийг улам үлэмж байгуулан мэдэлт ард нь хүүхэд ба охидоо сургуулийн танхимд оруулж, нийтээр сургаал хүмүүжлийг хүртээн газар бүр түгээмэл явуулан хөхүүлбээс дээш бадарч чадмой хэмээн бодмой" гэж сурган хүмүүжлийг түгээмэлжүүлэх чухал чанарыг дурдаж, сурган хүмүүжлээр Монголоо мандуулах үзлийг ухуулжээ.

"Бидний монгол угсаатны дахин мандахын бишрэлт замд чармайлцах чухал шүүмжлэл"-д: "Ядмаг, өвчин, мунхаг энэ гурван асуулт нь манай Монголын угсаатанд маш харшил болж амай, тийнхүү энэ өдөр манай Монгол дахиж мандахын замд урагшлая гэвэл урьдаар энэ хэдэн зүйлийг сайжруулахгүй бол үл болмой... 1. Гаралт хөрөнгийг хөгжин бадруулахад, тариалан ба тэжээврийн эл зүйлийн ажилд уран аргын хүн эрдэмтнийг дэмжин хүмүүжүүлэх хавсрал ажлыг дээш болгох хэрэгтэй. 2. Эрүүл хамгааллын бэлтгэл хийгээд байгуулалтыг бүрэн гүйцэтгэх хүн амын тоог үржүүлэх арга. 3. Утга соёлыг нээгдүүлэхэд утга бичгийн эрдэмтдийг дэмжин хүмүүжүүлэх эдүгээгийн шинжил сургаалын үндсийг нягтлан, утга зохион орчуулах ба сургуулийг түгээмэл болгохын зэрэг хэдэн зүйл буй" гэж утга соёлоо хөгжүүлж сурган хүмүүжлийг түгээмэлжүүлэхээр дамжиж үндэстнээ мандуулах арга замыг дурджээ.

Үүнээс гадна "Хөх туг" сонины "Өөрийн угсаа аймгийн утга үсгээ үл орхихыг чухал болгох нь", "Монгол угсаатны мандах хийгээд мухашгүй хүчлэн шамдах утга соёл", "Хөгжилтэй урагшлах санал", "Эдүгээгийн Монголын байдлыг үглэх нь", "Утга соёлын тул урагш чармайх монгол залуучуудын зорилт", "Угсаа аймгийн хөгжин бадрах нь", "Бидний угсаатан урагш чармайхыг хичээж угсаа аймгаа сайжруулах нь", "Монголын сургаал хүмүүжлэл ба шашин суртахууныг халж хувьсгахуйг чухал болгох нь" зэрэг нийтлэлд цөм утга соёлоо дээшлүүлж, сурган хүмүүжлийг хөгжүүлж угсаа үндэстнээ мандуулах үзлийг ухуулсан байдаг.

Чин улсын 200 гаруй жилийн үндэстнийг доройтуулах ноёрхол ба Иргэн

улсын засгийн газрын үндэстнийг мөхөөх бодлогын харгис дарлалыг хаширтал амссан монголчууд хагас зууны турш Монголоо мандуулах аль олон арга замыг эрэлхийлэн хатуужилтай тэмцсээр иржээ.

Ишлэл

1. Алтандалай. Монголын орчин үеийн түүх судлал. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2009. х.71.
2. "Ирэх өдрийн монгол". 1925.03.21. №35.
3. "Дахин мандсан Монголын чимээ". Чингис хааны 737 оны 1 сарын дэвтэр, №15.
4. Дахин мандсан Монголын чимээ. Чингис хааны 736 оны 6 сарын сарын дэвтэр, №9.
5. "Хөх туг". 8 дугаар оны 8 сарын 30, х.24.
6. "Хөх туг". 8 дугаар оны 8 сарын 16, х.22.
7. "Хөх туг". 8 дугаар оны 6 сарын 14, х.13.
8. "Монгол". 1930.05.25. №6.
9. Дахин мандсан Монголын чимээ. Чингис хааны 736 оны 11 сарын сарын дэвтэр, №13.
10. "Ирээдүйн монгол". Дундад ард улсын 24-р оны 9 сарын 01, №25.
11. "Ирээдүйн монгол". Дундад ард улсын 25-р оны 1 сарын 01, №23.
12. "Ирээдүйн монгол". Дундад ард улсын 24-р оны 7 сарын 01, №24.
13. "Ирээдүйн монгол". Дундад ард улсын 25-р оны 2-3 сар, №31-32.
14. "Дахин мандсан Монголын чимээ". Монгол утга соёлын хурлын дармал эх. 3 сарын дэвтэр, №6.
15. "Дахин мандсан Монголын чимээ". Чингис хааны 736 он, 12 сарын дэвтэр, №14.
16. "Дахин мандсан Монголын чимээ". Чингис хааны 736 он, 8 сарын дэвтэр, №11.
17. "Дахин мандсан Монголын чимээ". Чингис хааны 736 он, 4 сарын дэвтэр, №7.

18. “Дахин мандсан Монголын чимээ”.
Чингис хааны 737 он, 1 сарын дэвтэр,
№15.
19. “Хөх туг”. 8 дугаар оны 5 сарын 17, х.9.
20. “Хөх туг”. 8 дугаар оны 6 сарын 7, х.12.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Алтандалай. Монголын орчин үеийн түүх судлал. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2009.
2. “Дахин мандсан Монголын чимээ”.
Чингис хааны 736, 737 оны дэвтрүүд.
3. “Ирэх өдрийн монгол”. 1925.03.21.
№35.
4. “Ирээдүйн монгол”. Дундад ард улсын
24, 25-р оны дугаарууд.
5. “Хөх туг” сонин. 8 дугаар оны
дугаарууд.

Резюме

В данной статье автор всесторонне анализирует основные тематики и формы публикаций монгольских газет и журналов, вышедших в начале XX века во Внутренней Монголии. При этом автор обращает особое внимание тем материалам, которые освещали вопросы национальной безопасности и повышения национального самосознания монголов. Автор опираясь на многочисленные факты и яркие примеры газетных публикаций делает вывод о том, что газеты этого периода сыграли большую роль в повышении национальнго сознания и просвещении монгольских читателей Внутренней Моголии КНР.